ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөрөнгө оруулалт, худалдааны газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** СНАГ-2024/368/НА-СТА-ТШ3


Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,
Тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: П.Чанцалдулам
Утас: 261885 Цахим хаяг:chantsaldulamp@audit.gov.mn
Ахлах аудитор: Э.Энхбаатар
Утас: 261740 Цахим хаяг: enkhbaatare@audit.gov.mn
Аудитор: О.Наранбат
Утас: 261740 Цахим хаяг: naranbato@audit.gov.mn



Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2024 он


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХУДАЛДААНЫ ГАЗРЫН ДАРГА В.ЭНХБААТАР ТАНАА

2024.02.21 № 07/247

танай ____________-ны № ____________-т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөрөнгө оруулалт, худалдааны газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь шинж чанарын хувьд материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Хөрөнгө оруулалт, худалдааны газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Байгууллага нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах талаар арга хэмжээг авч ажиллаагүй, нийт 7,113.9 мянган төгрөгийн үргүй зардал гаргасан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын тэргүүн дэд, дэд, орлогч дарга болон дэд сайд, яамны төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн захирал, төсвийн байгууллагын дарга хот дотор албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно", 15 дугаар зүйлийн 15.2.3-д "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн "Агентлаг байгуулах тухай" 37 дугаар тогтоолоор "Хөрөнгө оруулалт, худалдааны газар"-ыг үүсгэн байгуулж, 30 хүний орон тоотой байхаар баталсан ч үйл ажиллагаа нь 2023 оны 3 дугаар улирлаас эхлэж, 15 хүний оронтойгоор ажиллаж байна.

**Аудитын гол асуудал**

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 12 дугаар сарын 20-ны А-1/2481 дугаар тогтоолоор Эдийн засаг, хөгжлийн яамнаас 16,343.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, GIZ төслөөс 10,267.0 мянган төгрөгийн хөрөнгийг балансаас балансt шилжүүлэн авсан.

**Бусад асуудлын хэсэг**

Хөрөнгө оруулалт, худалдааны газрын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 38 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийг тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

Z:\Yawsan_Bichig\2024\0221 SNAG-8.Docx

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **-** | **22,167,910.27** |
| **33** | **АВЛАГА** | **-** | **536,904.27** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | - | 68,083.27 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | - | 126,666.00 |
| **33500** | **Бусад авлага** | **-** | **342,155.00** |
| 33510 | Байгууллагаас авах авлага | - | 342,155.00 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | **-** | **20,280,843.00** |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | - | 4,941,843.00 |
| **34710** | **Урьдчилгаа тооцоо** | **-** | **15,339,000.00** |
| 34711 | Бараа материал бэлтгэх урьдчилгаа | - | 1,560,000.00 |
| 34712 | Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа | - | 13,779,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **-** | **1,350,163.00** |
| **35400** | **Хангамжийн материал** | **-** | **1,350,163.00** |
| 35410 | Бичиг хэргийн материал | - | 1,245,975.00 |
| 35420 | Аж ахуйн материал | - | 68,489.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | - | 35,699.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **-** | **61,863,487.68** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **-** | **61,863,487.68** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **-** | **61,863,487.68** |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | - | 59,062,253.20 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | - | (8,029,263.38) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | - | 19,850,373.44 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | - | (9,019,875.58) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **-** | **84,031,397.95** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **126,666.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **126,666.00** |
| **41300** | **Өглөг** | **-** | **126,666.00** |
| **41360** | **Бусад өглөг** | **-** | **126,666.00** |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | - | 126,666.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **-** | **83,904,731.95** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **-** | **83,904,731.95** |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **-** | **83,904,731.95** |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 83,904,731.95 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **-** | **84,031,397.95** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **I** | **Үйл ажиллагааны орлогын дүн (I)** | **-** | **364,124,458.10** |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | - | 11,092,058.10 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | - | 8,230,422.10 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | - | 126,666.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 126,666.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | - | 8,103,756.10 |
| 122 | Тусламжийн орлого | - | 2,861,636.00 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | - | 2,861,636.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | - | 353,032,400.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | - | 353,032,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 353,032,400.00 |
| **II** | **Үйл ажиллагааны зардлын дүн (II)** | **-** | **280,219,726.15** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | - | 280,219,726.15 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | - | 252,567,440.38 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | - | 94,029,916.78 |
| 210101 | Үндсэн цалин | - | 69,464,600.50 |
| 210102 | Нэмэгдэл | - | 18,135,316.28 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 6,430,000.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | - | 11,713,525.82 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | - | 7,965,197.54 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | - | 937,082.06 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | - | 749,665.65 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | - | 187,416.43 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | - | 1,874,164.14 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | - | 51,716,200.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | - | 4,676,400.00 |
| 210304 | Байрны түрээс | - | 47,039,800.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | - | 8,293,136.36 |
| 210401 | Бичиг хэрэг | - | 3,728,544.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | - | 1,375,445.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | - | 1,233,188.36 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | - | 1,955,959.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | - | 14,225,644.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 10,612,144.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 3,613,500.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | - | 18,775,588.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | - | 18,775,588.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | - | 47,409,220.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 44,300,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 3,109,220.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 6,404,209.42 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 5,000,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | - | 1,404,209.42 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | - | 27,652,285.77 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | - | 27,652,285.77 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 27,652,285.77 |
| **III** | **Үйл ажиллагааны ур дүн (III)=(I)-(II)** | **-** | **83,904,731.95** |
| **VI** | **Үйл ажиллагааны нийт ур дүн (VI)=(III)+(IV)-(V)** | **-** | **83,904,731.95** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *өгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **-** | **353,159,066.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **-** | **126,666.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **-** | **126,666.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **-** | **126,666.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 126,666.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **-** | **353,032,400.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **-** | **353,032,400.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 353,032,400.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **-** | **300,856,761.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **-** | **300,856,761.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **-** | **273,204,475.23** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **-** | **93,572,923.65** |
| 210101 | Үндсэн цалин | - | 68,992,298.55 |
| 210102 | Нэмэгдэл | - | 18,211,225.10 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 6,369,400.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **-** | **12,238,602.22** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | - | 8,353,297.50 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | - | 973,609.11 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | - | 749,665.65 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | - | 196,548.19 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | - | 1,965,481.77 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **-** | **51,716,200.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | - | 4,676,400.00 |
| 210304 | Байрны түрээс | - | 47,039,800.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **-** | **10,179,367.36** |
| 210401 | Бичиг хэрэг | - | 4,841,779.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | - | 1,617,600.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | - | 2,219,988.36 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | - | 1,500,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **-** | **27,743,231.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 19,938,631.00 |
| 210602 | Тавилга | - | 4,191,100.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 3,613,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **-** | **21,775,588.00** |
| 210701 | Гадаад албан томилолт | - | 18,775,588.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | - | 3,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **-** | **50,978,563.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 45,860,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 5,118,563.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **-** | **5,000,000.00** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 5,000,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **-** | **27,652,285.77** |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **-** | **27,652,285.77** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 27,652,285.77 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **-** | **52,302,305.00** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **-** | **52,302,305.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **52,302,305.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **-** | **52,302,305.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | 52,302,305.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **-** | **(52,302,305.00)** |
| **101** | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| **20** | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *//төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **1** | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **-** | **-** | **-** | **-** |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | - | - | - | - |
| 3 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | - | - | - | - |
| 4 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | - | - | - | - |
| 5 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| 6 | Өмчид гарсан өөрчлөлт | - | - | - | - |
| 7 | Зарласан ногдол ашиг | - | - | - | - |
| 8 | Тайлант үеийн үр дүн | - | - | 83,904,731.95 | 83,904,731.95 |
| **9** | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **-** | **-** | **83,904,731.95** | **83,904,731.95** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **353,032,400.00** | **325,506,780.23** | **27,525,619.77** | **92.2** |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | **353,032,400.00** | **325,506,780.23** | **27,525,619.77** | **92.2** |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **353,032,400.00** | **325,506,780.23** | **27,525,619.77** | **92.2** |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **93,816,000.00** | **93,572,923.65** | **243,076.35** | **99.7** |
| Үндсэн цалин | 74,505,000.00 | 68,992,298.55 | 5,512,701.45 | 92.6 |
| Нэмэгдэл | 12,961,600.00 | 18,211,225.10 | (5,249,625.10 | 140.5 |
| Унаа хоолны хөнгөлөлт | 6,349,400.00 | 6,369,400.00 | (20,000.00) | 100.3 |
| **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **12,277,200.00** | **12,238,602.22** | **38,597.78** | **99.7** |
| Тэтгэврийн даатгал | 8,379,400.00 | 8,353,297.50 | 26,102.50 | 99.7 |
| Тэтгэмжийн даатгал | 976,700.00 | 973,609.11 | 3,090.89 | 99.7 |
| ҮОМШӨ-ний даатгал | 752,200.00 | 749,665.65 | 2,534.35 | 99.7 |
| Ажилгүйдлийн даатгал | 197,200.00 | 196,548.19 | 651.81 | 99.7 |
| Эрүүл мэндийн даатгал | 1,971,700.00 | 1,965,481.77 | 6,218.23 | 99.7 |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **51,716,200.00** | **51,716,200.00** | **-** | **100.0** |
| Гэрэл, цахилгаан | 4,676,400.00 | 4,676,400.00 | - | 100.0 |
| Байрны түрээс | 47,039,800.00 | 47,039,800.00 | - | 100.0 |
| **Хангамж, бараа материалын зардал** | **13,781,400.00** | **10,179,367.36** | **3,602,032.64** | **73.9** |
| Бичиг хэрэг | 4,842,000.00 | 4,841,779.00 | 221.00 | 100.0 |
| Тээвэр, шатахуун | 1,617,600.00 | 1,617,600.00 | - | 100.0 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5,821,800.00 | 2,219,988.36 | 3,601,811.64 | 38.1 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,500,000.00 | 1,500,000.00 | - | 100.0 |
| **Эд хогшил, урсгал засварын зардал** | **82,152,600.00** | **80,045,536.00** | **2,107,064.00** | **97.4** |
| Багаж, техник, хэрэгсэл | 69,152,600.00 | 69,139,236.00 | 13,364.00 | 100.0 |
| Тавилга | 8,000,000.00 | 7,292,800.00 | 707,200.00 | 91.2 |
| Урсгал засвар | 5,000,000.00 | 3,613,500.00 | 1,386,500.00 | 72.3 |
| **Томилолт, зочны зардал** | **41,818,000.00** | **21,775,588.00** | **20,042,412.00** | 52.1 |
| Гадаад албан томилолт | 35,818,000.00 | 18,775,588.00 | 17,042,412.00 | 52.4 |
| Дотоод албан томилолт | 3,000,000.00 | - | 3,000,000.00 | - |
| Зочин төлөөлөгч хүлээн авах | 3,000,000.00 | 3,000,000.00 | - | 100.0 |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **52,471,000.00** | **50,978,563.00** | **1,492,437.00** | **97.2** |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 47,352,000.00 | 45,860,000.00 | 1,492,000.00 | 96.8 |
| Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 5,119,000.00 | 5,118,563.00 | 437.00 | 100.0 |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | **5,000,000.00** | **5,000,000.00** | **-** | **100.0** |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,000,000.00 | 5,000,000.00 | - | 100.0 |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **353,032,400.00** | **325,506,780.23** | **27,525,619.77** | **92.2** |
| **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **353,032,400.00** | **325,380,114.23** | **27,652,285.77** | **92.2** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Улсын төсвөөс санхүүжих | 353,032,400.00 | 325,380,114.23 | 27,652,285.77 | 92.2 |
| **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **61** | **31** | **30** | **50.8** |
| **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **1** | **1** | **0** | **100.0** |
| Төсвийн байгууллага | 1 | 1 | 0 | 100.0 |
| **АЖИЛЛАГСДЫН ТОО** | **30** | **15** | **15** | **50.0** |
| Удирдах ажилтан | 7 | 2 | 5 | 28.6 |
| Гүйцэтгэх ажилтан | 23 | 13 | 10 | 56.5 |
| **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **30** | **15** | **15** | **50.0** |
| Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 30 | 15 | 15 | 50.0 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 27.6 сая төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 27.6 сая төгрөгийн алдааг залруууллаа.

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл** */мянган төгрөгөөр/*

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Төсвийн гүйцэтгэлийн тайланд төвлүүлэх шилжүүлэг 27,652.3 мянган төгрөгийг санхүүжилтийн эх үүсвэрээс бууруулж, цэвэр дүнгээр тайлагнаагүйг залруулсан. | 1 | 27,652.3 | | | 1 | 27,652.3 | 1 | 27,652.3 | | | | |
| **Дүн** | **1** | **27,652.3** | | | **1** | **27,652.3** | **1** | **27,652.3** | | | | |

Аудитаар нийт 31.9 сая төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 7.1 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 24.8 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл** */мянган төгрөгөөр/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Байгууллага нь "Архив, албан хэрэг хөтлөлт"-ийн талаарх дотоод сургалтаа танхимаар зохион байгуулж, өглөө, өдрийн цай хоол, заалны түрээс зэрэгт нийт 1,515.8 мянган төгрөгийг зарцуулсан. | 1 | 1,515.8 | | | 1 | 1,515.8 | | | | | | |

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлгүй, ЭЗХЯ-нд бүртгэлтэй HYUNDAI SONATA-8 маркийн 0625 УБҮ улсын дугаартай суудлын автомашины дулаан зогсоолын төлбөрт 2,000.0 мянган төгрөг, угаалга, засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгслийн худалдан авалтад 3,598.1 мянган төгрөг, нийт 5,598.1 мянган төгрөгийг зарцуулж, үргүй зардал гаргасан байна. | 1 | 5,598.1 | | | 1 | 5,598.1 | | | | | | |
| Ажил гүйлгээний утгыг тодорхойгүй бичсэн, тухайлбал "Барааны үнэ" гэсэн гүйлгээний утгатай нийт 24,812.3 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн зарцуулалт гаргасан байна. | 1 | 24,812.3 | | | | | 1 | 24,812.3 | | | | |
| **Дүн** | **3** | **31,926.2** | **-** | **-** | **2** | **7,113.9** | **1** | **24,812.3** | **-** | **-** | **-** | **-** |

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 40.0 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** *(мянган төгрөгөөр)*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил** | | | | | | | | |
| АЙ ТИ ИНСАЙТ ХХК-аас 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдөр 19,989.4 мянган төгрөгийн Dell optiflex иж бүрдэл компьютер, ОРГИЛСТРИМ ХХК-аас 12 дугаар сарын 08-ны өдөр мөн 19,973.1 мянган төгрөгийн Dell optiflex иж бүрдэл компьютер, нийт 39.962.5 мянган төгрөгийн компьютер, тоног төхөөрөмжийг шууд худалдан авалтын үнийн дүнд батгаан, жижиглэн худалдан авалт хийсэн байна. | 1 | 39,962.5 | | | | | 1 | 39,962.5 |
| Дүн | 1 | 39,962.5 | | | | | 1 | 39,962.5 |
| **Нийт дүн** | **1** | **39,962.5** | | | | | **1** | **39,962.5** |